

ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН СТАНДАРТ, ХЭМЖИЛ ЗҮЙН ХЭЛТСИЙН СОРИЛТЫН ЛАБОРАТОРИ

ЗОРИЛГО: Хими, нян судлалын лаборатори нь хүний эрүүл мэнд болон байгаль орчинд сөргөөр нөлөөлж болох хими, физик, биологийн хүчин зүйлүүдийг хүнс, гоо сайхан, ахуйн хэрэглээний бүтээгдэхүүн, ундны усанд батлагдсан стандартын аргаар чанарын өндөр түвшинд шинжлэх зорилготой. Манай лабораторийн сорилт шинжилгээний үр дүн нь хүнсний чанар аюулгүй байдлын хяналтыг лабораторийн шинжилгээний үзүүлэлтээр баталгаажуулахаас гадна хүнсний хордлого, өргөн хэрэглээний бараа материалд агуулагдаж байж болзошгүй хортой болон онцгой хортой химийн нэгдэл, бичил биетүүдийг илрүүлэн тоо хэмжээг нь тогтоож өгдөг.

Лаборатори нь хими, нян судлал, хорио цээрийн шинжилгээнд 195 стандартыг шинжилгээндээ мөрдлөг болгон ашиглаж, үйл ажиллагаагаа “Стандартчилал, тохирлын үнэлгээний тухай” Монгол улсын хуульд үндэслэн MNS ISO/ IEC 17025:2018 стандартын зохих шаардлагын дагуу нийцүүлэн стандарт, журам заавруудыг шинээр боловсруулан батлуулан, эрхлэн явуулж байна. Стандартчилал, Хэмжилзүйн Газрын даргын 2014 оны 2-р сарын 04-ний өдрийн А/22 тоот тушаалаар анх удаа 2 жилийн хугацаатайгаар итгэмжлэгдсэн 2014 онд 3 үндсэн орон тоотой бүтэц батлагдаж, лабораторийн эрхлэгч, нян судлаач, шинжээч химийн шинжээч гэсэн орон тоогоор ажиллаж байна. 2016, 2019 онуудад давтан итгэмжлэлийн үнэлгээнд хамрагдаж итгэмжлэлийн хугацаагаа сунгуулан орон нутгийн ард иргэдийг эрүүл, баталгаа хүнс хэрэглэх, нөхцлийг бүрдүүлэн лабораторийн шинжилгээг тогтмол үзүүлэн ажиллаж байна. Аймгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Ус-Ду, Талын илч, Илчлэг шивээ ОНӨААТҮГазруудтай гэрээ байгуулж, хэрэглэгчдэд нийлүүлж буй төвлөрсөн усан хангамжийн усыг 14 хоног болон улиралд 1 удаа гэрээний дагуу шинжилгээнд хамруулж, ундны усны чанар аюулгүй байдлыг лабораторийн шинжилгээгээр хангуулан ажиллаж байна.

Хүнсний бүтээгдэхүүн үйлдвэрлэгч иргэн, цех, аж ахуй нэгжүүдтэй 2016 оноос эхлэн бүтээгдэхүүн шинжилгээнд хамруулах гэрээ байгуулан, орон нутгийн үйлдвэрлэгч нарын бүтээгдэхүүнийг улиралд 1 удаа графикийн дагуу заавал шинжилгээнд хамруулан, бүтээгдэхүүний чанарыг хянан баталгаажуулан хамтран ажиллаж байна.

2017 оноос эхлэн Говьсүмбэр аймгийн хэмжээнд төмс, хүнсний ногоо тариалагч хүлэмжийн аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуй нэгжийн талбайд хорио цээрийн үзлэгийг тариалалтын явцад 2 удаа зохион байгуулж, талбай дээр нь өвчин, хортон үүрлэсэн эсэхийг үзэж, зөвлөмж, зөвлөгөө өгч, хими, нян судлал, хорио

цээрийн лабораторид дээжийг авч үнэгүй шинжилгээнд хамруулан орон нутгийн ард иргэдийг эрүүл аюулгүй хүнс хэрэглэх боломжийг бүрдүүлэн , тариаланч иргэдээ дэмжин ажиллаж ирсэн

Нян судлалын шинжилгээг итгэмжлэлийн хүрээний 18 нэрийн сорьцонд 84, хорио цээрийн 3 нэрийн сорьцонд 6, химийн лаборатори нь итгэмжлэлийн хүрээний 25 нэрийн сорьцонд 128 үзүүлэлтээр тус тус сорилт гүйцэтгэж байна.

Химийн лаборатори



Нян судлалын лаборатори



200 м2 талбай бүхий түрээсийн байранд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 109 төрлийн химийг бодисыг хор аюулын ангиллаар ангилан төрөлжүүлж, зориулалтын татах шүүгээ болон шүүгээнд, зориудын агааржуулалтын системтэй өрөөнд хадгалдаг.